

ТҮҮХ, УЛАМЖЛАЛ

ХУТАГТ, ХУВИЛГААДААС ХЭД НЬ ҮЛДЭЭД БАЙГАА БОЛ

Академич Н.Ишжамц

Ойрмогхон тодорч Монголын шашны тэргүүн болсон түвэд угсааны IX богдыг эс дурдвал тамгатай томоохон хутагт, хувилгаад нэг ч үлдсэнгүй. Тамгагүй Хутагт, хувилгаадаас бага балчиртаа тодорсон цөөн хэд байж болох боловч бараг төлөв мэдэгдэхгүй байгаа юм. Хэрэв урьд адил айж болгоомжлоод гарч ирэхгүй байгаа бол ардчилал шинэчлэлийн одоо цагт тэгэх хэрэггүй болов уу. Тэднийг анх яаж тодруулсан, хүрээ хийд байхад энд хэрхэн амьдарч байсан, хойшид юу болсон зэрэг нь шашны түүх, намтар судлал, нүүдлийн соёл иргэншлийн асуудлыг тодруулахад эрхбиш чухал бөгөөд сонин юмны нэг мөн.

Миний хувьд намайг хүүхэд байхад манай нутагт, тухайлбал Дорноговь аймгийн Хөвсгөл суманд тодроод Банчен богдоор баталгаажигдсан ганцхан Хутагтыг мэднэ. Тэр нь 1925 онд мэндэлсэн, намын шинэ хүчний дээд сургууль, МУИС төгсөөд улсад олон жил үр бүтээлтэй ажилласан, эмнэлгийн тэргүүний ажилтан, магистр, чөлөөлөх дайнд оролцож ахмад дайчин болсон, цэргийн гавъяаны одон, хоёр алтан гадас одонгоор шагнагдсан ахмад ажилтан Ц.Гомбосүрэн юм. Номын худалдааны даргаар ажиллаж байсан, олны танил Гомбосүрэнг хутагтаар тодорч байсан гэдгийг мэдэх хүн ховор нь мэдээж хэрэг: түүнд гай болно гээд нутгийнх нь мэдэх хүмүүс ярьдаггүй байсан юм.

Уг нь Хөөврийн хийдийн хамба лам, Цүлтэм аранжимба Хутагтыг нас барсны дараа 1925 онд шарилыг шатаан хайлахад угаа нь дөнгөж төрөөд байсан Гомбосүрэн хүүгийн гэр дээр очиж, гал бадрах адил нэг дүрэлзээд замхарсан, тийм учраас нутгийн лам, хар хүмүүс түүнийг аранжимбын хойт дүр бололтой хэмээн таамаглаад шашны янз бүрийн үзлэг, сорилт хийж үзэхэд тэнцсэн гэдэг. 1927 онд гурван настайд нь Хөөврийн хийд дээр Хутагт хэмээн залаад Банчен богдод элч, захидал илгээж лавлан асуусанд мөн хэмээсэн тул Хутагт, хувилгаан хэмээн алдаршиж эхэлжээ. 5 настайд нь түүнийг тус хийдэд албан ёсоор шавилуулан суулгасан байна.

* ШУА-ийн Олон улсын судлалын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан

Гэвч эцэг нь Лхасад 10 жил сурч маарамбын дамжаа барьсан, боржгин овгийн хашир, туршлагатай тойн лам байсан зэрэг учир 1930-аад оны эхний ээдрээтэй цагийн аяг гярхай ажиглан, Гомбосүрэн хувгүүнийг нэн даруй хар болгож, хөдөө гарган малчин болгосон бөгөөд тэрээр ерөөс бага балчир байсны ачаар хэлмэгдүүлгийн үед өртөлгүй үлдсэн ажээ.

Энэ бүхэн болон бас буй зүйлсийн тухай Хөөврийн хийдийн лам байсан, 80 настан ахмад буурал Со.Гунгаачоймболын бичсэн “Ц.Гомбосүрэнгийн бага насны үе” хэмээх 30 гаруй тал хуудас, ихээхэн сонирхолтой бөгөөд чухлын чухал дурдатгалаас нэлээд дэлгэрэнгүй тодорхой олж мэдэж болно. Дурдатгалаа Гунгаачоймбол гуай Улсын түүхийн төв архив, Түүхийн хүрээлэн, Улсын номын санд шилжүүлэх бололтой байна билээ. Уг нь бүрэн эхээрийг хэвлэн нийтэлбэл нэн сонирхолтой бөгөөд ашигтай баймаар харагдана.

НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАБЖАЙН ХОНГОРЫН ХИЙД

Академич Н.Ишжамц

Төв Азийн бүддийн ертөнц даяар алдар цууриатсан говийн Ү ноён хутагт Данзанрабжайн нэрэмжит сүм хийд Монгол, Түвд, Тангад, Хятад даяар хаана ч байдаггүй байсан мэт байж, гайхал төрүүлдэг байв. Түүний байгуулсан Галбын гурван хийд, тэр байтугай оршин амьдарч байсан Хамарын хийд нь хүртэл түүний нэрэмжит болсонгүй.

Гэтэл 1990-ээд оны үеэр Говь Мэргэн вангийн хошуу, түүнээс салбарласан Хутаг уулын хошуу, дараа үеийн Дорноговь аймгийн Хөвсгөл сумын товч түүх зохиох явцад Улсын түүхийн архиваас Данзанрабжайн нэрэмжит нэгэн сүм хийд байсан баримт материал цөөнгүй олдов. Юу гэвэл Хөвсгөл сумын зүүн урд захын Хонгорын хийд хэмээх жижигхэн хийдийг Данзанрабжайлин хийд хэмээн хувьсгалын үеийн тоо бүртгэлийн баримтанд ч байнга нэрлэсэн байв. Баримт бичигт түүний нэрийг эсхүл монголоор Хонгорын хийд хэмээн бичээд хаалтанд алба юм шиг заавал Данзанрабжайлин хийд хэмээн түвдээр бичсэн, эсхүл монголоор шууд Данзанрабжайлин хийд хэмээн бичсэн үзэгдэнэ. Хуучцуулаас лавлаж асуухад тэр тухай мэдэх хүнгүй, харин Хонгорын хийдийн хамба лам Содномдаржаа тойны ач хөвгүүн, мөн тэр хавийн Хөөврийн хийдийн лам байгаад хожим улсад алба хаасан ахмад зүтгэлтэн, 80 настан Сө.Гунгаачоймбалын “Ц.Гомбосүрэнгийн бага насны үе” (1999, гар бичмэл) дурдатгалын дотор тэр хавийн сүм хийдийн тухай дурдсанаас үзвэл: “Тавдугаар ноён хутагт Данзанрабжай зарим хийдийг нь удаа дараа

рабнайж байсан юм гэнэ билээ гэдэг яриа их байсан. Хонгорын хийдийг Данзанрабжайлин, Хөөврийн хийдийг Дашдаржаалин хэмээн нэрлэж иржээ. Аль алин нь улааны, шарын хоёр ёсыг хослуулсан хийд байсан гэж би боддог”, “Тавдугаар ноён хутагт өөрөө голдуу зуны улиралд энэ хоёр хийдэд ирж хурал номын ажилд биеэр оролцон хурж, намайлдаж, сүсэгтэн, өглигийг эздэд адис хүртээдэг, удаахи дүүрүүд нь ч тогтмол ирж хурдаг байжээ. Долдугаар ноён хутагт 1920-иод оны эцсээр ирж хурсан нь хамгийн сүүлчийнх нь байсан бололтой. Ноён хутагтыг (ҮИ-ыг -Н.И) залран ирэхэд байнга бараа болж үйлчилдэг, ард олонд “гэгээний Гэндэнжав” хэмээн алдаршсан лам байсан бөгөөд 1930-аад оны эцсээр баривчлагдан хэлмэгдэж эдүгээ цагаадсан” (7-8-р тал) гэсэн байна.

Урьд нь түвдээр Шаддубдаржайлин хэмээгдэж байсан Хонгорын хийдийг Данзанрабжайн нэрэмжит болгосон нь тохиолдлын хэрэг биш байв. Говийн ноён хутагтуудын дөрөвдүгээр дүр нь хүний амины хэрэгт холбогдож яллагдсан учир манжийн хаан түүний дүрийг дахин тодруулахыг хоригложээ. Гэтэл нутгийн лам нар, харчууд нийлж хэлэлцээд Хонгорын хийдийн цорж лам, Улаваан аграмба хэмээх хутагтын хойт дүрийг тодруулах нэрийдлээр Ү ноён хутагтыг бага балчир байхад нь анх гарган ирж нэр дэвшүүлснийг тухайн үеийн Монголын богд гэгээн хүлээн зөвшөөрч баталгаажуулсан юм. Тийм учраас Хонгорын хийдийг хожмын үед Данзанрабжайлин хийд болгож, түүний хойт дүүрүүд нь тэнд үе үе очиж хурал хурахад оролцдог, мөн төлөөлөгчөө тэнд байлгадаг болсон ажээ.

Нэгэнт Хонгорын хийд Данзанрабжайлин хийд хэмээн албан ёсоор нэрлэгдэх болсон тул их ёсыг сайн мэдэгч дараа үеийн аль ч зүтгэлтэн бусад ямарваа хүрээ хийдийг түүний нэрэмжит болгож түвдсэнгүй.

Жич, Хонгорын хийд нь 7 настай багаахан хийд байсан атал Дилав Хутагт Жамсранжав дурдатгалынхаа дотор Монголын хүрээ хийдийн газрын зурагт Дорноговь аймгийн сүм хийдээс хоёрыг нэр зааж оруулсан нь Данзанрабжайн нэр сүртэй холбоо бүхий, санамсаргүй хэрэг биш болов уу.